



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/291

Булган сум

“Уулзвар бүсийн Математикийн олимпиад”
зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” 25 дугаар тогтоол, “Код бичих” хөтөлбөрийг батлах тухай XI/77 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ардын боловсролын тэргүүний ажилтан Математикийн багш С.Энхбаатарын нэрэмжит Уулзвар бүсийн математикийн олимпиад”-ыг зохион байгуулахад 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах “Код бичих” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3.Олимпиадыг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Боловсролын газрын дарга (Ц.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР



6326010405